



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Анхбаяр
Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Аудитын санал дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026 02 24 № 144

танай _____ ны № _____ т

АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.ТӨГСБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд байгууллагаар 3 дугаар байр эзэлж мөнгөн шагналаар шагнуулсан байна.

Аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

2024 оны батлагдсан төсөв 1,327.8 сая төгрөг, 2025 онд 2,052.3 сая төгрөг болж 724.5 сая төгрөгөөр өссөн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар баталсан Дотоод хяналт шалгалт явуулах журмыг мөрдөж ажилласан байна.

6326050107

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31.	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	62,562.71	96,675.38
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,531,798.64	1,450,864.72
	Нийт хөрөнгийн дүн	1,594,361.36	1,547,540.10
	Нийт өр төлбөрийн дүн	457,150	2,730.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,593,904.21	1,547,540.10
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,594,361.36	1,547,540.10
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,728,131.03	2,103,447.02
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,436,776.09	2,149,372.98
	Үйл ажиллагааны үр дүн	291,354.93	(45,925.96)
	Үйл ажиллагааны бус үр дүн		-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	291,354.93	(45,925.96)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,302,549.27	1,590,736.06
	Тайлант оны үр дүн	291,354.93	(45,925.96)
	Эцсийн үлдэгдэл	1,593,904.21	1,544,810.09
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,368,589.71	2,072,974.60
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,367,370.99	2,074,977.58
	Үйл ажиллагааны ЦМГ	1,218.72	(2,002.98)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(4,268.80)	(4,014.90)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(3,050.08)	(6,017.88)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,434.63	7,384.55
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,384.55	1,366.67
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	2,044,658.84
	Урсгал зардал	-	2,044,658.84
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	2,022,006.44
	Улсын төсвөөс санхүүжих	-	2,022,006.44
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	22,652.40

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /цаашид ШШГГ/ нь “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах, хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, иргэдэд шуурхай үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад хууль, тогтоомжууд, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. Бодлогын баримт бичиг үйл ажиллагаанд нийцэж байгаа болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд байгууллагаар 3 дугаар байр эзэлж мөнгөн шагналаар шагнуулсан байна.

Аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тав. Аудитын гол асуудал

2024 оны батлагдсан төсөв 1,327.8 сая төгрөг, 2025 онд 2,052.3 сая төгрөг болж 724.5 сая төгрөгөөр өссөн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын

даргын 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар баталсан Дотоод хяналт шалгалт явуулах журмыг мөрдөж ажилласан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 159 мэдээлэл мэдээлэхээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5. "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн аудитаар санхүүгийн тайлангийн тодруулгыг журамд нийцүүлсэн бэлтгэсэн эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,380.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс тус зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөг данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцэст авлага 17.4, түлш халаалтын өглөг 1,099.3, байгууллагад төлөх 264.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заасан заалттай бүрэн нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага болон өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А.Т тоо	Тоо	Дүн	
Жилийн эцэст авлага 17.4, түлш халаалтын өглөг 1,099.3, байгууллагад төлөх 264.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.	1	1,380.7					1	1,380.7					
Дүн	1	1,380.7					1	1,380.7	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний шилэн дансны 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0